

2025 оны 04 сарын 11 өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.8.13, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний сарын үндсэн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тус тус тогтоосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны хуралд оролцсон сар бүр үндсэн цалингийн 25 хувьтай тэнцүү хэмжээний нэмэгдлийг тооцож олгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний сарын цалин хөлсийг тэдгээрийн хуралд оролцсон ирцийг үндэслэн тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР